

Биелэлт гаргасан:

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ний

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Ш.АМАР-ОТГОН

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БАЙРШИЛТАЙ
“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН “ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС ДАХИН БОЛОВСРУУЛАХ”
ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2615134/

Хянасан:

НБОГ-ын ХБОБНХ-ийн МЭРГЭЖИЛТЭН

С.СҮХЦООЖ

Улаанбаатар хот

2024 он

Агуулга.

Нэг. Төслийн товч танилцуулга

1.1. Төслийн товч танилцуулга	3-4
1.2. Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт, барилга байгууламж	4-5
1.3. Үйлдвэрийн технологи, хүчин чадал	5-9
1.4. Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн	9-13
1.5. Хог хаягдал	14-17

Хоёр. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.1. БОМТ-ийн тухайн жилийн төлөвлөгөө	19-34
2.2. 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан	35-61

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр	“Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр”-ийн төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Хай Би Ойл” ХК
Улсын бүртгэлийн дугаар	9010001063
Регистрийн дугаар	2615134
“Аюултай хог хаягдал” цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар	0000009
Төслийн байршил	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонголон /18135/, Товчооны зам 59 тоот
Талбайн хэмжээ	8,865м ²
Утас	88119740, 99904034,
Төслийн зорилго, ач холбогдол	Үйлдвэрлэл, техникийн ашигласан хаягдал тос болон гидрийн шингэнийг орчин үеийн технологийн VSEP мембранан шүүлтүүрийн аргаар дахин боловсруулж, шаардлага хангасан М-100 маркийн мазут бэлтгэх зорилготой бөгөөд мөн байгаль орчин болоод хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах, аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилготой.
Ажиллах хоног	240 хоног
Цахилгаан, ус хангамж	Цахилгаан нь МЗХННУлаанбаатар Төмөр Замын шугам сүлжээнд холбогдсон. Үйлдвэрийн хэрэглээний болон ажилчдын ундны усыг өөрийн эзэмшлийн худгаас хангадаг.



Зураг 1. Төслийн талбайн байршил (Google Earth)

1.2 Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт, барилга байгууламж:

Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт 8,865 метр квадрат талбайг эзлэн үйлдвэр нь байрлана.



Зураг 2. Үйлдвэрийн барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт

Хүснэгт 1. Үйлдвэрийн барилгын талбайн хэмжээ

№	Нэр	Хэмжээ, м2
1	Үйлдвэрийн агуулах	338.31
2	Оффисын барилга	45.7
3	Агуулах	34.96
4	Харуулын байр	36.2
5	Гүний худаг	16.36
6	Трансформатор	16.61
7	Граж	31.53
8	Ногоон байгууламж	106.65
9	Түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах сав	360.33
10	Суурь	88.71
11	Бетон талбай	65.39
12	Сул чөлөөтэй талбай	
Нийт		8,865.65 м2

1.3 Үйлдвэрийн технологи, хүчин чадал

“Хай Би Ойл” ХК нь 2008 оноос хойш Хонг Конгийн Данвелль компанийн үйлдвэрлэсэн VMAT I-36 системийн техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийг ажиллуулан өөрийн орны уул уурхай болон бусад салбарын техник, тоног төхөөрөмжөөс гарч хаягдаж буй ажилласан маслыг дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэнд оруулж байна.

Хүснэгт 2. Үйлдвэрийн хүчин чадал, үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоон утга
1	Үйлдвэрийн хүчин чадал, тн	2400
2	Төслийн хугацаа, жил	10
3	Төслийн хугацаанд цэвэршүүлэх тос, тн	14000
4	Жилд цэвэршүүлэх ажилласан тос.тн	1400
5	Сард цэвэршүүлэх ажилласан тос.тн	200
6	Жилд сул зогсох сар	5
7	Жилд ажиллах сар	7
8	Жилд ажиллах хоног	140
9	Жилд ажиллах цаг	1260
10	Цаг ашиглалт	0.88
11	Хоногт ажиллах цаг	9.0
12	Хоногт ажиллах бүтээлтэй цаг	8.0
13	Цагийн бүтээл, тн	1.3
14	Хоногийн бүтээл, тн	10.0

Энэхүү дахин боловсруулах үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед жилд 2400тн техникийн хаягдал тос дахин боловсруулах хүчин чадалтай юм. Үйлдвэрийн үйл ажиллагаа дулаан улиралд буюу 4-10 дугаар саруудад нийт 7 сар ажиллана. Энэ үед жилд 1400 тн, 10 жилд 14000 тн ажилласан тос боловсруулна.

Үйлдвэр нь ажилласан тосыг центрифуг, нарийн шүүлтүүр, ууршуулагч болон VSEP мембранан шүүлтүүрийн аргаар цэвэрлэдэг автомат удирдлагын системтэй орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд дараах зарчмаар ажиллана.


Түүхий эд (техникийн хаягдал тос)-ыг үйлдвэр доторхи 25 м³ –ийн савнаас насосоор шахаж 10м³ багтаамжтай тунгаагуур саванд өгнө. Тунгаагуурт ажилласан тосны найрлаганд байх ус, элс, том хэмжээтэй хатуу хольцуудыг тунгаан механик цэвэрлэгээ хийж, найрлагыг нь жигдрүүлэх процесс явагдана. Тунгаагуурын дээд хэсгээс хаягдал тос 2.0м³-ийн багтаамжтай завсрын саванд өөрийн урсгалаар юүлэгдэн орно. Хаягдал ажилласан тосыг завсрын савнаас насосоор соруулан авч центрифугт шахах ба энд төвөөс зугатах хүчний үйлчлэлээр суспенз болон дунд зэргийн хэмжээ, масстай механик хольц нь цэвэрлэгдэнэ. Центрифугээр дамжин 2 дахь цэвэрлэгээ хийгдсэн тос нь дулаан солилцуулагч болон нэрэгчинд тодорхой даралттайгаар өгөгдөнө. Энд хаягдал ажилласан тосны температурыг дээд тал нь 100°С хүртэл нэмэгдүүлж түүний найрлагад байгаа ус, чийгийг ууршуулан конденсацид оруулах процесс явагдана.

Дулаан солилцуулагчаар дамжин халсан тос нь дахин 20 меш буюу 0,8мм хэмжээтэй шүүлтүүрээр шүүгдэн эндээс 3.0м диаметртэй 20м³ багтаамж бүхий конус хэлбэрийн ёроолтой дамжуулах сав гэж нэрлэгдэх тэжээлийн саванд өгөгдөнө. Техникийн хаягдал тосыг халаах үед өндөр температурын үйлчлэлээр хэсэг хугацааны дараа түүнээс ус чийг нь ууршина. Техникийн хаягдал тосыг механик хольцууд болон уснаас салгаснаар өтгөрсөн тос буюу мазутыг үйлдвэрлэнэ.






Зураг 3. VMAT I-36 зургаан багц тоног төхөөрөмж



Зураг 4. VMAT I-36 төхөөрөмжийн технологийн хяналтын самбар



Зураг 6. Дахин боловсруулах үйлдвэрийн технологийн дараалал

Үйлдвэрийн технологи: “Хай Би Ойл” ХК нь ажилласан тосыг VSEP мембранан шүүлтүүрийн аргаар хөндлөн урсгалт төхөөрөмжийн тусламжтайгаар ажилласан тосыг мембранан шүүлтүүрийн хөндлөн огтлолын дагуу шахаж өгөх арга дээр үндэслэнэ. Энэ нь хатуу хольц хөндлөн урсгалын үйлчлэлээр ийнхүү түрэгдэн зайлах боловч урсгалын хуйралтаар эргээд шүүлтүүрийн гадаргуу дээр цуглардаг. Хөндлөн урсгалт шүүлтүүрт тосыг маш өндөр даралтаар шахаж өгдөг. Шүүх процессийн явцад мембранан шүүлтүүрийн гадаргуу дээр хатуу хольцоос тогтсон давхарга үүсч шүүгдэж буй тосны урсгалыг саатуулж улмаар мембранан шүүлтүүрийн бүтээмжийг их хэмжээгээр бууруулдаг. Өөрөөр хэлбэл хатуу хольц мембранан шүүлтүүрийн гадаргуу дээр хоёрдогч мембранан гадаргууг бий болгодог. Иймээс мембранан шүүлтүүрт ажилласан тосыг нам даралттай урсгалаар өгөх нөхцөл хязгаарлагдмал байдаг.

1.4 Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн

Түүхий эд: Үндсэн түүхий эд нь машин, тоног төхөөрөмжийн (трактор, автомашин, уул уурхайн хүнд машин механизм, комбайн, зам, барилгын ба мод бэлтгэлийн техник, хөдөө аж ахуйн, суурь машин болон бусад) узел ба агрегатуудад ашиглагдаж байсан хаягдал тос, гидрийн шингэн юм. Монголд улсад ажилласан масло буюу техникийн хаягдал тосны чанарт тавих стандарт гэж одоогоор байхгүй байна. Харин ОХУ-д мөрддөг ГОСТ 21046-86 “Нефтепродукты отработанные. Общие технические условия” стандартын шаардлага ёсоор үйлдвэрийн аргаар сэргээлт хийх ажилласан тосыг дараах нормчлогдсон үзүүлэлтүүд бүхий 2 бүлэг (ММО ба МИО) болгон ангилдаг.

Тус үйлдвэр нь “Аюултай хог хаягдал” болох техникийн ажилласан маслыг нийслэлийн авто засварын газрууд болон уул уурхайн компаниудаас гэрээний дагуу цуглуулан авч байгаль орчинд ээлтэйгээр дахин боловсруулдаг.



Зураг 7. Байгаль орчинд хаягдаж болзошгүй аюултай хог хаягдал болох техникийн ажилласан тос

Хүснэгт 3. Цуглуулсан техникийн хаягдал тос болон боловсруулалтанд орсон тос

Түүхий эд	Нэгж	2023 оны үлдэгдэл тос	2024 онд цуглуулсан тос	Боловсруулалтанд орсон тосны хэмжээ
Техникийн хаягдал тос	литр	269,197	1,705,071	1,974,268

Хүснэгт 4. Техникийн хаягдал тос цуглуулсан гэрээт газрууд

<i>д/д</i>	<i>Харилцагч компаниуд</i>	<i>нийт өгсөн / литр/</i>
1	Оюутолгой ХХК	762,750
2	Паблик сервис ХХК	622,671
3	Таванбогд ХХК	26,550
4	Петронано ХХК	1,000
5	МСМ ХХК	18,700
6	Автоланд ХХК	5,100
7	Хера экуйпмент ХХК	15,000
8	Зэс эрдэнийн хувь ХХК	7,000
9	Делта авто сервис	3,800
10	Хүслэн сүбээдэй ХХК	1,800
11	Богд моторс ХХК	25,050
12	Түвшин саруул ХХК	4,800
13	Hyundai /офицор/	1,600
14	Riko trans	2,800
15	Топ моторс ХХК	22,000
16	Жэйд ХХК	36,800
17	Мак ХХК	2,000
18	Цагдаагийн авто баак	1,500
19	Дашваагжил ХХК	2,000
20	Тахилт хайрхан транс ХХК	4,900
21	Уулс ноён ХХК	10,500
22	Wolf center	2,000
23	Онно трейд ХХК	4,400
24	Батхүлэг ХХК	11,850
25	Шунхлай ХХК	3,000
25	Шарын голХК	31,800
27	Ачбуян ХХК	2,000
28	Хэт моторс ХХК	3,500
29	Монгол Хьондай ХХК	1,800
30	Тавантолгойн түлш ХХК	2,400
31	Авто комплекс ХХК	2,500
32	Бавариа ХХК	1,200
33	Өрмөн уул ХХК	1,000
34	Тод ундрага ХХК	10,000
35	Монрок ХХК	5,000
36	Боса ХХК	800
37	Говьхангайн хөдөлмөр ХХК	12,000
38	Смарт Моторс ХХК	2,000
39	Тун Гуа майнз ХХК	2,200

40	Барловорлд монголиа ХХК	15,000
41	Хүчит хүлгийн хурд ХХК	1,200
42	Старчейз автмотив лимитд ХХК	500
43	Цолмон /хувь хүн/	24,000
44	Хадбаатар /хувь хүн/	22,000
45	Мөнхийн төгс мичид ХХК	2,000
46	Хүдэр мөнх ХХК	8,000
47	Нутгийн буян групп ХХК	2,500
48	Приус центр ХХК	1,500
49	Би Эс Ай ХХК	1,200
50	Шижирбаатар/хувь хүн/	9,200
51	Баасанхүү/хувь хүн/	24,000
52	Эрдмин ХХК	1,400
	Нийт дүн	1,705,071


Хүснэгт 5. Боловсруулалт хийгдэх ажилласан тосны нормчлогдсон үзүүлэлтүүд

Үзүүлэлтийн нэр	Нормчлогдсон үзүүлэлтүүд		Шинжлэх арга
20°C ба 50°C үеийн кинематик зууралдлага (Cст)	40<35	13-40 5-35	ГОСТ 26378.3-84 ГОСТ 33-82
Задгай тиглед тодорхойлсон асах температур, °C, доошгүй	100	120	ГОСТ 26378.4-84
Механик хольцын массын даль, %, ихгүй	1	1	ГОСТ 26378.2-84
Усны масс доль, %, ихгүй	2	2	ГОСТ 26378.1-84
Бохирдлын агуулга	Байх ёсгүй		ГОСТ 26378.2-84

1.4.2 Эцсийн бүтээгдэхүүн


Тус үйлдвэрийн технологиор автомашины хөдөлгүүрийн хаягдал тос болон гидрийн шингэнийг цэвэршүүлэн М-100 маркийн мазут үйлдвэрлэдэг байна. Дахин боловсруулсан тос буюу мазутыг уурын зуух болон цахилгаан станц, асфальт бетон зуурмагийн үйлдвэр, халаагуур эсвэл хайлуулах зуух, цементийн зуух гэх мэт үйлдвэрлэлд галалгааны түлш хэлбэрээр хэрэглэдэг.

Мазутад тавигдах техникийн нөхцөлийг “Газрын тосны бүтээгдэхүүн, Мазут Техникийн ерөнхий шаардлага MNS 3828:2008” стандартад нийцүүлдэг. Уг стандартад барьцалдах чанараараа хөнгөн түлш болох флотын мазут Ф-5, Ф-12 мөн дунд ангиллын М-40 болон хүнд ангиллын М- 100 маркийн зуухны мазут гэж тус бүр ангилсан байдаг.



АМБЕР ХХК

Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний
MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори



СОРИЛТЫН ҮР ДУНГИЙН ТАЙЛАН №02751/24

ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ		
Дээж ирүүлсэн байгууллагын нэр	Хай Би Ойл ХК	
Дээжийг авсан газар	Улаанбаатар, Монгол	
Дээжийн төрөл	Мазут	
Дээж авсан объект	Сав №9	
Дээж авсан ажилтан <small>Л/эр, албан тушаал/</small>	Хай Би Ойл ХК-ийн ажилтан	
Дээжийн хэмжээ	1.0 литр	
Дээжийн лацны дугаар	-	
Дээжийн нэмэлт тайлбар	-	
Дээж авсан огноо:2024.04.24	Хүлээн авсан огноо:2024.04.25	Шинжилсэн огноо:2024.04.26

СОРИЛТЫН ҮР ДҮН

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Сорилт гүйцэтгэсэн стандарт	Норм MNS 3828:2008 /M100/	Үр дүн
1 Хувийн жин 15 ⁰ С-д	г/см ³	MNS 0481	-	0.8744
2 Кинематик зууралдлага 50 ⁰ С-т	мм ² /с	MNS 0480	-	37.85
100 ⁰ С-т, ихгүй			50.0	17.26
3 Механик хольцын агуулга, ихгүй	%	MNS 0322	1.5	байхгүй
4 Усны агуулга, ихгүй	%	MNS 0332	1.0	байхгүй
5 Дөл үүсгэх температур, багагүй	⁰ С	MNS 0328	110.0	-
6 Царцах температур, ихгүй	⁰ С	MNS 3192	/25.0/	/-35.0/
7 Өнгө*	-	MNS ISO 2049	-	хар

Тайлбар: *-ИХ-д ороогүй үзүүлэлт

Шинжилгээ хийсэн химич

Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч



М.Мялагмаа

Б.Адъяа

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251

Энэхүү тайлан нь тухайн дээжний хувьд хүчинтэй.
Хуулбарлан хэвлэхийг хориглоно.


0125655

Зураг 8. Мазут шинжилгээ



АМБЕР ХХК

Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний
MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори



СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №04067/24

ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ		
Дээж ирүүлсэн байгууллагын нэр	Хай Би Ойл ХК	
Дээжийг авсан газар	Улаанбаатар, Монгол	
Дээжийн төрөл	Мазут	
Дээж авсан объект	Сав №9	
Дээж авсан ажилтан /Нэр, албан тушаал/	Хай Би Ойл ХК-ийн ажилтан	
Дээжийн хэмжээ	1.0 литр	
Дээжийн лацны дугаар	-	
Дээжийн нэмэлт тайлбар	-	
Дээж авсан огноо:2024.06.13	Хүлээн авсан огноо:2024.06.14	Шинжилсэн огноо:2024.06.14

СОРИЛТЫН ҮР ДҮН

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Сорилт гүйцэтгэсэн стандарт	Норм MNS 3828:2008 /M100/	Үр дүн
1 Хувийн жин 15 ⁰ С-д	г/см ³	MNS 0481	-	0.8747
2 Кинематик зууралдлага 50 ⁰ С-г 100 ⁰ С-г, ихгүй	мм ² /с	MNS 0480	- 50.0	47.11 10.96
3 Механик хольцын агуулга, ихгүй	%	MNS 0322	1.5	байхгүй
4 Усны агуулга, ихгүй	%	MNS 0332	1.0	байхгүй
5 Дөл үүсгэх температур, багагүй	⁰ С	MNS 0328	110.0	-
6 Царцах температур, ихгүй	⁰ С	MNS 3192	/25.0/	/-44.0/
7 Өнгө*	-	MNS ISO 2049	-	хар

Тайлбар: *-ИХ-д ороогүй үзүүлэлт

Шинжилгээ хийсэн химич

Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч



М.Мядагмаа

Б.Адьяа

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251

Энэхүү тайлан нь тухайн дээжний хувьд хүчинтэй.
Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

00014820

Зураг 9. Мазутын шинжилгээ

1.5 Хог хаягдал

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллаж байна. Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах (хоолны үлдэгдэл, цаас хайрцаг сав баглаа боодол) хүмүүсийн хэрэглэж байсан зүйлс багтана. Нийт 8 хүн ажиллах бөгөөд жилд 140 хоног ажиллана гэж тооцвол өдөрт 4 кг, сард 120кг (8 хүн хоног 0,5кг хатуу хог хаягдал/хоногт*30 хоног), жилд 840кг хог хаягдал гарахаар байна. Харин үйлдвэрээс гарах саарал усыг 3 дамжлагат тунгаах саванд хийсний дараа хөргөлтийн системд дахин ашиглах байна.



Зураг 10. Хог ачилт



ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 43 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан "Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам", Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01-р тогтоолыг үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

2.2 Энэхүү гэрээ

НЭГ ТАЛААС: Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс /цаашид татварын байцаагч гэх / Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх "Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв" ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/с
НӨГӨӨ ТАЛААС: Сайн Би Ойл ХХК 2615134 иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага /доогуур зурах/ дахин боловруулах үйлдвэр үйл ажиллагааны чиглэлтэй /цаашид үйлчлүүлэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 2024 оны 01 -р сарын 01-ны өдрөөс эхлэн

2024 оны 12 -р сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сар бүрийн 25-ны дотор гэрээнд заасан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хураан авах эрхтэй.

4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн

55 дугаар зүйлээс 73 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хийх эрхтэй.

4.3 Аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тээвэрлэгч байгууллагатай тооцоо нийлж байх үүрэгтэй.

4.4 Татварын байцаагч нь аж ахуй нэгж байгууллага бүрээс хог хаягдлын хураамжийг тогтсон хугацаанд, тогтмол хурааж тээвэрлэгч байгууллагын ачилт хийх боломжийг хангах үүрэгтэй.

4.5 Аж ахуй нэгжээс нэхэмжлэлээр хураасан хог хаягдлын хураамжийн задаргааг тээвэрлэгч байгууллагад дараа сарын 3-ны дотор аж ахуй нэгж, байгууллага гаргаж өгөх.

ТАВ. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Тээвэрлэлт хийсэн аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Татварын хэлтэстэй тооцоо нийлж байх үүрэгтэй.

5.2 Гэрээний үнийн дүн болон ачуулж байгаа хог, тээвэрлэлтийн зардал бодит байдал дээрээ хоорондоо нийцэхгүй тохиолдолд тээвэрлэгч байгууллагаас татварын хэлтэст ИТХ-ийн 10/01 дугаар тогтоолд заасан тарифын дагуу үнийн санал гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5.3 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг тээвэрлээгүйтэй холбоотой гомдол гаргавал тооцоо нийлж, протокол үйлдэж, тээвэрлэлтийн баримтаар нотлогдоогүй бол хохирлыг тээвэрлэгч байгууллага барагдуулах үүрэгтэй.

5.4 Хог хаягдлын ачилт хийсэн хуудас, нэхэмжлэлийг сар бүрийн 20-ны дотор Татварын хэлтэс өгч, ачилт хийсэн аж ахуй нэгж, иргэн, албан байгууллагын мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хогийг тээвэрлэхгүй.

ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтсон хогийн цэгт хаях болон овор хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урьд өдөр нь тээвэрлэгч байгууллагын 70000818 дугаарын утсанд ажлын цагаар дуудлага өгнө. Гэрээнд заасан тарифийн дагуу тогтмол рейсийн тоогоор тээвэрлүүлэх.

6.2 Татварын байцаагчаас хог хаягдлын хураамж тушаасан баримт, Тээвэрлэгч байгууллагаас хог хаягдлыг ачуулсан баримтыг шаардан авах эрхтэй.

6.3 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцаасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуй нэгж байгууллага болон иргэн өөрөө хариуцна.

6.4 Үйлчлүүлэгч нь тогтсон хугацаанд татварын байцаагчид гэрээний дагуу хог хаягдлын хураамжийг төлж байх, Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд, зориулалтын цэгээс, уут саванд хийсэн хог хаягдлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

6.5 Ажиллаагүй гэсэн шалтгаанаар хог хаягдлын хураамж төлөөгүй аж ахуй нэгж, иргэн, албан байгууллага тухайн харьяалагдах хорооноос ажиллаагүй гэсэн албан бичиг авч баримтжуулах үүрэгтэй.

6.6 Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасны дагуу шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байх үүрэгтэй.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1 Эрх зүйн баримт бичиг болон стандартад өөрчлөлт орсон тухайн цаг үед гэрээ байгуулсан талуудаас санал оруулах нь нээлттэй.

7.2 Үйлчлүүлэгч /1рейсийн/ үйлчилгээний хураамжийг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 14 дугаар тогтоолоор тогтоосон тарифын дагуу /сар бүрийн.....төгрөг/, /улиралд.....төгрөг/, /жилдтөгрөг/, /захиалгаар..120,000...төгрөг/ төлбөрийг төлнө.

7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаврыг үүсгэн банкинд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хогийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувиар алданги тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан"Төхижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНӨААТҮГ төлөөлж:

Албан тушаал: Хуулийн зөвлөх

Нэр: М.Цэрэнням

Гарын үсэг /...../

Аж ахуй нэгж, байгууллагыг төлөөлж:

Албан тушаал /...../

Нэр /...../

Гарын үсэг /...../

Утас /...../

Хаяг: СХД 20-р хороо, Сонгинохайрхан 18135, Төвч400ЖЫ Зол 591000Б

Зураг 11. Хог хаягдлын гэрээ

1.5.2 Унд ахуйн хэрэглээний ус: Үйлдвэрт нийт 8 хүн ажиллана. Иймд ундны усыг байгальорчны Сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын хавсралтын дагуу тооцоо хийдэг.

Хүснэгт 6. Усны хэрэглээний хоногийн дундаж норм

№	Усны хэрэглээний нэр, төрөл	Ус хэрэглээний хоногийн дундаж норм, л/хон
1	Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангагддаг гэр хороолол	20

8*20-160л/хоног буюу 0,16м³/хон болж байна.

Жилд нийтдээ 140 хоног ажиллана гэж тооцохоор нийт 22.4м³ ус хэрэглээнд ашиглана.

Хүснэгт 7. Хог хаягдлын дахин ашиглалт

Эх үүсвэрээс гарах хог хаягдлынтөрөл		Дахин ашиглалт	Устгал	Дахин боловсруулах, ашиглах	Зайлуулах арга хэмжээ	
Ахуйн	20 03 01 20 01 03	Гал тогооны хаягдал	+	-	Хоолны үлдэгдлийг ажилчид нохойныхоол болгодог	Дахин ашигладаг иргэн, аж ахуйн нэгжид нийлүүлэх
	19 12 01	Цаас хайрцаг	+	+	Дахин ашигладаг иргэн, аж ахуйн нэгжид нийлүүлэх	
Үйлдвэрээс	05 01 04	Асгарсан тос	-	+	-	Тусгай зөвшөөрөлтэй компаниар
	05 01 08	Тосны лаг	-	+	-	
	05 01 99	Төмрийн үлдэгдэл, үртэс	-	+	-	
	16 07 99	Саарал ус	+	-	Үйлдвэрийн хөргөлтийн усандаа ашигладаг	
Шингэн		Унд ахуйн ус	+	-		Тусгай зөвшөөрөлтэй компаниар

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Зорилго, хамрах хүрээ

Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Хай Би Ойл ХК-ийн Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн БОННУ-ний ажлын явцад хот тохижилтын үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж барилгажилт болон үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн зорилго: Төслийн барилгын үе шат болон үйл ажиллагаанаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах болон ургамал, хөрс, ус, агаарыг чанарын өөрчлөлтийг хянах үйл ажиллагаа бодитой төлөвлөх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго оршино.

Гол зорилтууд:

Нарийвчилсан үнэлгээнд тодорхойлогдож үнэлэгдсэн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулах

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулах

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах, хэлэлцүүлэх хувиар төлөвлөх

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэхээр зорьж буй арга хэмжээний талаар **жил бүрийн төлөвлөгөөг** Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн **батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг** холбогдох газруудад **хүргүүлж байх** шаардлагатай.

Үүнээс гадна тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан “БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр хэрэгжих явцад биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагагүй юм.

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлгөөний зардал

№	Зардлын утга	2024 он
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	1300
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	61000
3	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3600
4	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1000
5	Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	3000
5	Осол, эрсдэлийн менежментийн зардал	1000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1740
7	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	3000
8	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлгийн зардал	300
9	Хог хаягдлын менежмент	11500
10	Ногоон байгууламж байгуулах зардал	1215
Нийт зардлын дүн		88655

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож үнэлсэн. Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нарийвчлан тогтоов.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл	Санал болгож буй урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хариуцах	Хяналт явуулах байгууллага	Хяналтын шалгуур
				2024 он			
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
1	Төслийн үйл ажиллагаа	Төслийн түүхий эд ашигласан хаягдал тос болон бэлэн болсон бүтээгдэхүүн тээвэрлэх, явцад тоосжилт үүсэж агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулна	Шаардлагагүй машин, техник хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах; Ил задгай хог хаяхгүй байх анхааруулга, санамж бүхий самбар тэмдэгжүүлэлтийг хийх;	1000.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК,	Агаарын бохирдлыг бууруулахаар хийгдсэн арга хэмжээ
2			Ажлын байранд агаарын чанарын хяналтыг явуулж ажилчид өртөж байгаа нь багажийн хэмжилтээр тогтоогдсон тохиолдолд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэмж төлөвлөх	Үйл ажиллагааны зардлаар		Итгэмжлэгдсэн лаборатори, байгууллага	MNS4990:2000, MNS 4585:2016
3			Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах. Төслийн талбайд 3 сар тутамд агаарын чанарын хяналт хийнэ. Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарт ялгарах хий дэх бохирдуулагч бодисын хэмжээ нь стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	Төсөл хэрэгжүүлэгч	Итгэмжлэгдсэн лаборатори, байгууллага	MNS4990:2000, MNS 4585:2016
4	Нефт бүтээгдэхүүн	Агаарын чанарыг доройтуулна	Агаар орчинд нефт бүтээгдэхүүн ууршилт дээр хяналт тавих, мониторинг хийх. Нефт бүтээгдэхүүн ил задгай алдагдахаас сэргийлэх	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК,	Агаарын бохирдлыг бууруулахаар хийгдсэн арга хэмжээ
	Төслийн үйл	Ашигласан хаягдал тос	Ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн хэвийн ажиллагааг хангах	600.0	Төсөл хэрэгжүүлэгч	Байгаль орчны аудит	Агаарын тухай хууль, MNS 4585:2016

	ажиллагаа	хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлөх	Ашигласан хаягдал тосыг тээвэрлэх, дахин боловсруулахдаа техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах	600.0	Төсөл хэрэгжүүлэгч		Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Төслийн үйл ажиллагаа	Үйлдвэрийн ажилчид шуугианы бохирдолд өртөх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан	Төсөл хэрэгжүүлэгч	Байгаль орчны аудит	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
			Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ашиглалтад хяналт тавих	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан	Төсөл хэрэгжүүлэгч	Байгаль орчны аудит	
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
5	Машин, механизмын ашиглалт	Хөрсний бохирдол явагдана	Техникийн ашигласан тос цуглуулах цэгүүдээс төсөл хэрэгжих талбай хүртэлх замыг засаж сайжруулах, тоосжилт ихтэй үед тоос дарах арга хэмжээ авч ажиллах. Барилга байгууламж болон зам талбайд урсгал засвар хийх.	1300.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК,	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд
6			Төслийн талбайгаас авсан хөрсний дээжид хүнд металлын бохирдол хэдий илрээгүй ч цаашид тогтмол “Хөрс бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартад заасан хүлцэх хэмжээнд байгаа эсэхийг байнга хянаж	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд

			дотоод мониторинг хийж байх, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн судлаачдаас зөвлөмж авч багасгах, бууруулах арга хэмжээ авах;				
7	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Газрын хэвлий болон хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Техникийн үзлэг үйлчилгээ, хяналтын тохиргоо, ашиглалтын үеийн ачаалал, цахилгаан хэлбэлзэл, газардуулгын системийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулж байх Байгууламж нь цэвэр, бохир усны системтэй, цахилгааны төвийн эх үүсвэртэй, үерийн далан, сувагтай, бохир ус цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, Байгаль орчны хэрэгжилтийн тайлан	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд
8	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Газрын хэвлий болон хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Нефт бүтээгдэхүүний ил болон далд агуулах нь нефт бүтээгдэхүүний шүүрлээс хөрс, газрын доорх болон гадаргын ус бохирдохоос хамгаалах зориулалттай доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах системтэй байх бөгөөд төслийн бүх үе шатанд хэвийн ажиллагааг хангаж ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, Байгаль орчны хэрэгжилтийн тайлан	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд
9	Төслийн үйл ажиллагаа	Хөрсөн бүрхэвчийг доройтуулна	Тэжээвэр амьтан, гадны хүн орохооргүй, хашаа хамгаалалттай, байнгын харуултай, гадна талдаа хаяг, био-аюулгүйн таних тэмдэг байрлуулсан байх ба эдэлбэр газрын 30%-аас доошгүй газарт ногоон байгууламжтай байна.	2300.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, Байгаль орчны хэрэгжилтийн тайлан	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд
10	Төслийн үйл ажиллагаа	Хөрсний бохирдол явагдана	Ашигласан хаягдал тос, нефт бүтээгдэхүүнтэй ажиллах заавар зөвлөгөө, ашигласан хаягдал тос хүрээлэн буй орчинд алдагдсан тохиолдолд авах хариу арга хэмжээний хөтөлбөр боловсруулж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
11	Усны нөөцийн ашиглалт	Усны нөөцийн хомсдол	Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэх нөхцөлийг хязгаарлах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх үүднээс усны чанарын байдалд байнгын хяналт, мониторингийг дотооддоо болон гаднын байгууллагаар хийлгүүлэх	1000.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, БОУАӨЯ-МХГ	-
12			Технологийн хэрэглээний явцад гарах хаягдал усыг эргүүлэн ашиглана. Үйл ажиллагааны онцлог хүчин чадалд тохирсон цэвэрлэх байгууламж байгуулах	60 000.0		Хай Би Ойл ХК, БОУАӨЯ-МХГ	Бохир усыг цэвэршүүлэх ажиллагаа, MNS-4943:2015
13			Унд ахуйн хэрэглээний усыг хангаж буй гүний худгийн тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах, тоолуурын заалтыг үндэслэн ашигласан усны төлбөрийг барагдуулах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, БОУАӨЯ-МХГ	-
14			Ахуйн шингэн хаягдал хуримтлуулах цооногт хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар		Хай Би Ойл ХК, БОУАӨЯ-МХГ	-
15			Ус хангамжийн худгийн усны түвшний бууралт, горим, чанарын өөрчлөлтийг байнга хянах зорилгоор усны чанарын шинжилгээг хийж үр дүнг хянаж ажиллах	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан		Хай Би Ойл ХК, БОУАӨЯ-МХГ	MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт
Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
16	Төслийн үйл ажиллагаа	Ургамлан нөмрөг талхлагдана	Ил хөрстэй болон эвдрэлд орсон талбайг нөхөн сэргээж ургамалжуулах замаар гадаргаас сул тоос, шороо хийсэх нөхцөлийг бууруулах, шаардлагагүй шороон зам үүсэхээс сэргийлэх, тэмдэгжүүлэх, мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотойгоор ногоон байгууламж байгуулж, тогтмол арчилж байх	1000.0	Төсөл хэрэгжүүлэгч	Газрын алба, БОГ	Байгаль хамгаалах ажил

17			Ногоон байгууламжид ашиглах нутгийн ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тарьж ургуулах, харь зүйлийн ургамлын үр, суулгац суулгахаас татгалзах	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнд тусгагдсан		ТХ	Бүрдүүлсэн үрийн нөөц
Нутгийн оршин суугчид, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах							
18	Төслийн үйл ажиллагаа	Мэдээллийн хангалтгүй байдал	Дүүрэг, хорооны удирдлагуудад өөрийн үйл ажиллагааны талаар жил бүр танилцуулга хийх,	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Дүүрэг, хорооны засаг захиргаа	
19		Ажлынбайрны хангамж	Ажлын байраар орон нутгийн иргэдийг хангах,	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Дүүрэг, хорооны засаг захиргаа, БОГ	
20		Ажилчдынэрүүл мэнд	Бүх ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгийн журамд заасан үзлэг шинжилгээнд хамрагдахаас гадна В вирүст хепатат, татрангийн эсрэг дархлаажуулалтад заавал хамруулах, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр хангах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч		
21	Төслийн үйл ажиллагаа	Ажилчдынэрүүл мэнд	Бүх ажилтнууд нь сертификат бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн холбогдох сургалтуудад хамрагдсан байна.	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Онцгой байдлын газар	Дадлага эзэмшүүлэх сургалт явуулсан ажлын протокол
22			Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шаардлагын дагуу авч хэрэгжүүлэх Галын аюулгүй байдлыг хангах, дотоод дүрмийг сахих, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрийг нийт ажиллагсадад ашиглуулж сургах, сургалт зохион байгуулах	1000.0	Төсөл хэрэгжүүлэгч	Онцгой байдлын газар	Дадлага эзэмшүүлэх сургалт явуулсан ажлын протокол

23	Төслийн үйл ажиллагаа	Ажилчдын эрүүл мэнд	Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулах Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйц том, тод бичиж хананд байрлуулах	500.0	Төсөл хэрэгжүүлэгч	Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил
24	Төслийн үйл ажиллагаа	Ажилчдын эрүүл мэнд	Нефт бүтээгдэхүүн хүрээлэн буй орчинд алдагдахаас сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байна. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорх ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байна	1000.0	Төсөл хэрэгжүүлэгч	Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил
25	Төслийн үйл ажиллагаа	Ажилчдын эрүүл мэнд	Нефт бүтээгдэхүүн хүрээлэн буй орчинд алдагдахаас сэргийлэх, шатах тослох материал байгуулах, үйл ажиллагаа явуулах, засвар үйлчилгээ хийх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.	500.0	Төсөл хэрэгжүүлэгч	Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил
26	Төслийн үйл ажиллагаа	Ажилчдын эрүүл мэнд	Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаа гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Нийслэл МХГ, Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил

27	Төслийн үйл ажиллагаа	Ажилчдын эрүүл мэнд	Нийт ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, хог хаягдлын менежментийн сургалтад хамруулах. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2011 оны 08 дугаар захирамжаар баталсан хүн нэг бүрийн анхан шатны тусламжийн үүргэвчинд байвал зохих зүйлсийн жагсаалтын дагуу бэлтгэж, бэлэн байдлыг хангуулах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Онцгой байдлын газар	Дадлага эзэмшүүлэх сургалт явуулсан ажлын протокол
Нийт зардлын дүн				67,900,000			

3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдлийг гаргахгүй байх юм. Иймээс байгууламж нь 2023 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, өглөө бүр ХААБ сургалтыг хийхээр төлөвлөсөн. Мөн авто ослоос сэргийлэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээ 10 ш байрлуулахаар төлөвлөсөн. Төслийн дэд бүтэц, барилга байгууламж, ногоон байгууламжаас бусад хэсгийг бүрэн цементжүүлэх, асгаралтын журам боловсруулж мөрдөж ажиллахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 5 575 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангах болон эмнэлгийн үзлэгийн зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2024 он		
2	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид		Үйл ажиллагааны зардалд орно.	Хай Би Ойл ХК	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2024 он		
3	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, солиж цэнэглэж ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх		Иж бүрэн	700.0	Хай Би Ойл ХК	Галаас хамгаалах тухай хууль
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид	Өдөр бүр	300.0	Хай Би Ойл ХК	ХААБ зааварчилгаа
5	шаардлагатай газруудад мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна	гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем; аюултай хог хаягдал хариуцсан ажилтны овог нэр, утасны дугаартай самбар	Төслийн талбайд	10	200.0	Хай Би Ойл ХК	
6	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь ажилтнуудыг жилд нэг удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.		5 хүн.	1000.0	Эрүүл мэндийн байгууллага	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2024 он		
7	Аюул устгах төлөвлөгөө боловсруулж батлуулж мөрдөж ажиллах	Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах хэмжээгээр агаар, хөрс, усанд санамсаргүй болон санаатайгаар аюултай хог хаягдал алдах, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах үед үүсэх эрсдэлийг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах зорилго бүхий аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөтэй байна.			3000.0	Онцгой байдлын газар	
	Нийт	1000.0					

4. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт хэрэгжиж буй Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүний үйл ажиллагааны явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг

Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгаа

Төслийн БОМТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Хүснэгт 4. Хяналт-шинжилгээ хийх

7.1. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорх ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байх бөгөөд хөтөлбөрийн дагуу хяналт-шинжилгээг хийнэ.	7.2.1.хяналт-шинжилгээний төрөл, хугацаа, талбай; 7.2.2.хяналт-шинжилгээ хийх арга; 7.2.3.хариу арга хэмжээ.	
7.3. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног нь газрын гадаргаас доош босоо чиглэлд газрын доорх усны дээд үе хүртэл үргэлжлэх бөгөөд байгууламжийн газрын доорх усны хяналт-шинжилгээний систем нь газрын доорх усны хамгийн дээд үеэс дээж авах боломж бүхий гүнд суурилагдсан, тогтоосон цэгт гаргасан, хангалттай тооны хяналтын худагтай байна.		
7.4. Газрын доорх усны хяналтын худгаас дээж авах бүртгээ газрын доорх усны түвшинг хэмжиж, бүртгэл хөдөлнө.		
7.5. Газрын доорх усны хяналт-шинжилгээний үргэлжлэх хугацаа нь тухайн байгууламжийн үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл авсан өдрөөс байгууламжийг хаах хүртэл байна.		
7.6. Газрын доорх усны цооног гаргах зөвшөөрлийг тухайн орчны газрын доорх усны суурь судалгаа, цооногийн гүний болон байршлын зураг төсөлд үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.		
7.7. Гүний худаг болон гадаргын усанд хяналт-шинжилгээ хийх талбай нь байгууламжийн хилээс 1500 метрийн радиус дотор байна.		
7.8. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгууламжийг хаасан тохиолдолд Хог хаягдлын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу хаалтын дараах хяналт-шинжилгээг хийнэ.		
7.9. Хаалтын дараах хяналт-	7.9.1.байгууламжийн бүрэн	

шинжилгээг дор дурдсан чиглэлээр хийж, тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ:	бүтэн байдал; 7.9.2.шүүрэл ялгарч буй эсэх; 7.9.3.газрын доорх усны хяналт-шинжилгээ.	
7.10. Газрын доорх усны хяналт-шинжилгээг тухайн байгууламжийг хаасан өдрөөс хойш газрын доорх усны чанар дараалсан 3 жилийн турш стандартын шаардлага хангаж байгааг нь нотлогдсон тохиолдолд зогсооно.		
